

ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо: 2021 оны 02 дүгээр сарын 10-ны өдөр

Тендер шалгаруулалтын нэр: **Хөдөлмөр хамгаалалын хамгаалах хэрэгсэл 3-н багц нийлүүлэх**

Тендер шалгаруулалтын дугаар: **ДЦС-4/2021-48**

“ДЦС-4” ТӨХК нь эрх бүхий тендерт оролцогчдоос Хөдөлмөр хамгаалалын хамгаалах хэрэгсэл 3-н багц нийлүүлэх нийлүүлэх тухай цахим тендер ирүүлэхийг урьж байна.

Энэхүү ажлын тендер шалгаруулалт нь цахим худалдан авах ажиллагааны системээр зарлагдаж байгаа цахим тендер тул www.tender.gov.mn хаягаар орж дэлгэрэнгүй мэдээлэл болон цахим тендерийн баримт бичгийг үнэ төлбөргүйгээр татан авна уу.

Тендерт оролцогч нь тендер илгээхийн өмнө 50.000 /тавин мянга/ төгрөгийг цахим систем ашиглан төлсөн байх ёстой.

Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн 30 хоногийн дотор хүчинтэй байна. Тендерт оролцогч нь санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

- 1. Борлуулалтын хэмжээ:** Сүүлийн 2 жилийн жил бүрийн борлуулалтын орлого нь санал болгож буй үнийн дүнгээс багагүй байна. /2019, 2020 он/
- 2. Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ:** Тендерт санал болгож буй үнийн дүнгээс багагүй байна.
- 3. Сүүлийн 2 жилд хэрэгжүүлсэн ижил төстэй ажил:** Сүүлийн 2 жил буюу 2019, 2020 онд ижил төстэй гэрээт ажил гүйцэтгэсэн байна.

Тендерийн хамт төсөвт өртгийн 2% үнийн дүнтэй тендерийн баталгаа ирүүлнэ. Засгийн газрын бондоор ирүүлсэн тендерийн баталгааг хүлээн зөвшөөрнө.

Тендерийг 2021 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн 10.00 цагаас өмнө цахим системээр илгээх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг 2021 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн 10 цаг 30 минутад нээнэ.


Монгол улсын гарал үүсэлтэй бараанд давуу эрх тооцно.

Сонирхсон этгээд бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 20 дугаар хороо, Эрчим хүчний гудамж,
“ДЦС-4” ТӨХК-ийн Захиргааны байр, 3 дугаар давхар, 312, 313 тоот өрөө
Худалдан авах ажиллагааны хэлтэс Утас 7018-1309, 7000-1357, 7017-1357, Факс

7018-1309 7000-1357

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Ү.ТӨМӨРХУЯГ